



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/116

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага
худалдаа дахин зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 10.1.2, 10.1.4, 10.2 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд батлах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 23-ний өдрийн 10/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 4 нэгж талбарт газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг цахимаар дахин зохион байгуулсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх газрын анхны үнэ, хэмжээ байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Дуудлага худалдааны зарыг 2023 оны 06 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж, холбогдох журмын дагуу дахин зохион байгуулахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын ...*2013*...оны...*06*...дугаар
сарын ...*02*...ны өдрийн...*2/116*...дугаар
захирамжийн хавсралт

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ
ГАЗРЫН АНХНЫ ҮНЭ, ХЭМЖЭЭ БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

№	Эзэмшүүлэх газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар
1	2	3	4	5	6
1	8 айлын орон сууцны зүүн талд	4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	1000	800000	3195236
2	Эмчийн байрны хойд талд	Худалдаа үйлчилгээ	1300	1040000	3119691
3	Хуучин хогийн цэг	Мод үржүүлгийн газар	10000	4800000	3174125
4	Хуучин хогийн цэг	Мод үржүүлгийн газар	5000	2400000	3174126

--oOo--